ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Баянтэс сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2024/118/НА-СТА-ТШЗ

---

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он


Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

“Хаан соёмбо аудит” ХХК-ийн гэрээт аудитор Ж.Буянтогтох

Утас: 9904 2814

Цахим хаяг: buyanaa99042824@gmail.com


---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**


1. Хараат бус аудиторын дүгнэлт 3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7

3. Санхүүгийн тайлангийн тодруулга........8

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11

4. Аудитын тайлан........13

4.1 Ерөнхий зүйл ........13

4.2 Материаллаг байдал ........14

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт........14

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........14

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........15

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........16

5. Аудитын илрүүлэлт ........16

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4
   2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
   2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4
   2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5
   2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6
   2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга......8
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11
4. Аудитын тайлан......13
   4.1 Ерөнхий зүйл ......13
   4.2 Материаллаг байдал ......14
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт......14
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ......14
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ......15
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ......16
5. Аудитын илрүүлэлт ......16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.11 № 72

танай ____________-ны № ____________-т

БАЯНТЭС СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ч.ДАШХҮҮ-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянтэс сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянтэс сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Баянтэс сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 39 ажил төлөвлөж, хэрэгжилт 100 хувьтай дүгнэгджээ. Байгууллагын болон багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд бүрэн хамрагдаж, өмнөх жилийн үнэлгээгээ ахиулан 4 дүгээр түвшингээс 2 дугаар түвшинд орж, багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр багш нарын 80 хувь 1-4 дүгээр түвшинд нь үнэлэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Баянтэс сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 153 нэр төрлийн 287,576.9 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлж, ашиглах хугацааг сунгаагүй, урсгал засварын зардлаас шинээр барих 100 хүүхдийн дотуур байрны геологийн судалгааны төлбөрийг төлсөн, шатахууны жолоочийн тооцооны хуудас хэн, хэзээ, хаашаа, ямар ажлаар явсан нь тодорхойгүй, автомашинаар явсан албан тушаалтны гарын үсэггүй, тооцоог бодоогүй, дуудсан албан бичиггүй шатахуун зарцуулсан, шатахууны зарцуулалтад хяналт тавьдаггүй зөрчил байна.

Бусад асуудлын хэсэг

Баянтэс сумын Ерөнхий боловсролын сургуульд аймгийн Онцгой байдлын газрын гал түймрийн улсын байцаагчийн гал түймэр гарсан тухай 2024 оны 12 сарын 25-ны 27/10/03 дугаар актаар тус сургуулийн 220 хүүхдийн хичээлийн байр эд зүйлийн хамт шатаж төрийн өмчид 459,396.1 мянган төгрөгийн хохирол учирсныг тогтоосон байна. Баянтэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 сарын 27-ны 11 дүгээр тогтоолоор 41,596.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 37,099.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, бусад хангамжийн материалыг акталж данснаас хасаж, сургуулийн хичээлийн байр, хоолны заал, бусад үндсэн хөрөнгийг актлах зөвшөөрөл авахаар Орон нутгийн өмчийн газарт хүсэлт хүргүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-ҮНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| SORT_ID | Үзүүлэлт | ҮЛДЭГДЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 310,093,652.76 | 269,330,470.83 |
| 2 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 164,155,816.51 | 152,640,119.73 |
| 8 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 164,155,816.51 | 152,640,119.73 |
| 9 | Төгрөг | 164,155,816.51 | 152,640,119.73 |
| 10 | Төрийн сангийн харилцах | 161,241,316.51 | 149,725,619.73 |
| 14 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 2,914,500.00 | 2,914,500.00 |
| 27 | АВЛАГА | (0.00) | 134,900.91 |
| 28 | Ажиллагсадтай холбогдсон авлага | (0.00) | 134,900.91 |
| 60 | БАРАА МАТЕРИАЛ | 145,937,836.25 | 116,555,450.19 |
| 61 | Түүхий эд материал | 879,000.00 | 990,000.00 |
| 63 | Эм боох материал | 879,000.00 | 990,000.00 |
| 66 | Хангамжийн материал | 145,058,836.25 | 115,565,450.19 |
| 68 | Аж ахуйн материал | 87,095,674.91 | 59,770,775.85 |
| 72 | Хүнсний материал | 20,338,500.00 | 24,040,170.00 |
| 73 | Бусад хангамжийн материал | 37,624,661.34 | 31,754,504.34 |
| 86 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,281,702,506.19 | 1,402,989,247.63 |
| 106 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,281,702,506.19 | 1,402,989,247.63 |
| 108 | Биет хөрөнгө | 1,235,918,006.19 | 1,357,617,247.63 |
| 109 | Барилга, байгууламж | 1,067,936,839.20 | 1,067,936,839.20 |
| 110 | Хуримтлагдсан элэгдэл | (118,973,632.76) | (160,300,988.24) |
| 111 | Авто тээврийн хэрэгсэл | 41,335,000.00 | 41,335,000.00 |
| 112 | Хуримтлагдсан элэгдэл | (41,335,000.00) | (41,335,000.00) |
| 113 | Машин, тоног төхөөрөмж | 322,077,113.33 | 518,741,353.33 |
| 114 | Хуримтлагдсан элэгдэл | (171,738,879.72) | (216,082,818.06) |
| 115 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 157,386,275.60 | 121,272,759.20 |
| 116 | Хуримтлагдсан элэгдэл | (90,006,707.98) | (59,306,877.32) |
| 121 | Түүх соёлын дурсгалт зүйлс | 31,496,000.00 | 31,496,000.00 |
| 122 | Бусад үндсэн хөрөнгө | 12,188,599.00 | 12,188,599.00 |
| 123 | Хуримтлагдсан элэгдэл | (12,188,599.00) | (12,188,599.00) |
| 125 | Номын фонд | 37,740,998.52 | 53,860,979.52 |
| 126 | Биет бус хөрөнгө | 45,784,500.00 | 45,372,000.00 |
| 127 | Програм хангамж | 2,400,000.00 | 2,400,000.00 |
| 128 | Хасагдуулга | (1,987,500.00) | (2,400,000.00) |
| 129 | Бусад биет бус хөрөнгө | 45,372,000.00 | 45,372,000.00 |
| 137 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 1,591,796,158.95 | 1,672,319,718.46 |
| 138 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | - | 70,939,206.00 |
| 139 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 70,939,206.00 |
| 164 | Өглөг | - | 70,939,206.00 |
| 165 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | - | (0.00) |
| 170 | Бусад өглөг | - | 70,939,206.00 |
| 171 | Байгууллагад төлөх өглөг | - | 70,870,206.00 |
| 172 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 69,000.00 |
| 214 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 1,591,796,158.95 | 1,601,380,512.46 |
| 215 | Засгийн газрын хувь оролцоо | 1,591,796,158.95 | 1,601,380,512.46 |

| | | | |
|---|---|---|---|
| 216 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 363,659,810.00 | 363,659,810.00 |
| 217 | Өмч: -Төрийн өмч | 363,659,810.00 | 363,659,810.00 |
| 223 | Хуримтлагдсан үр дүн | 579,288,020.19 | 588,872,373.70 |
| 224 | Өмнөх үеийн үр дүн | 579,288,020.19 | 579,288,020.19 |
| 225 | Тайлант үеийн үр дүн | - | 9,584,353.51 |
| 227 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 648,848,328.76 | 648,848,328.76 |
| 231 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 1,591,796,158.95 | 1,672,319,718.46 |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| SORT_ID | ITEM_NAME | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,810,334,966.04 | 2,417,042,631.00 |
| 76 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 88,263,566.04 | 99,800,131.00 |
| 77 | Нийтлэг татварын бус орлого | 88,263,566.04 | 99,800,131.00 |
| 81 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 88,263,566.04 | 99,800,131.00 |
| 83 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,915,766.00 | 3,877,600.00 |
| 86 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 85,347,800.04 | 95,922,531.00 |
| 111 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,722,071,400.00 | 2,317,242,500.00 |
| 112 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,574,636,600.00 | 2,142,734,000.00 |
| 113 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,574,636,600.00 | 2,142,734,000.00 |
| 129 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 147,434,800.00 | 174,508,500.00 |
| 130 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 147,434,800.00 | 174,508,500.00 |
| 147 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 1,624,961,222.68 | 2,407,458,277.49 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,624,961,222.68 | 2,407,458,277.49 |
| 149 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,562,916,142.26 | 2,302,355,861.29 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 1,117,382,178.09 | 1,680,194,616.89 |
| 151 | Цалин | 767,397,233.59 | 1,028,724,177.00 |
| 152 | Нэмэгдэл цалин | 293,640,728.00 | 549,311,039.89 |
| 154 | Урамшуулал | 56,344,216.50 | 102,159,400.00 |
| 157 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 142,805,413.56 | 207,862,629.27 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 99,281,603.87 | 142,700,549.30 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 11,291,082.61 | 16,894,346.19 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 9,002,065.97 | 8,489,077.60 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 2,111,875.23 | 7,955,731.37 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 21,118,785.88 | 31,822,924.81 |
| 164 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 139,762,609.58 | 139,210,633.80 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 8,331,489.58 | 5,867,176.80 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 131,361,120.00 | 133,288,457.00 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | 70,000.00 | 55,000.00 |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | - | 54,881,233.16 |
| 171 | Бичиг хэргийн материал | - | 143,000.00 |
| 172 | Тээвэр, шатахууны зардал | - | 17,639,177.10 |
| 178 | Бараа материал актасны зардал | - | 37,099,056.06 |
| 181 | Нормативт зардал | 45,218,020.00 | 52,323,930.00 |
| 182 | Эм | - | 389,000.00 |
| 183 | Хоол | 45,218,020.00 | 51,934,930.00 |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,300,500.00 | 15,605,000.00 |
| 189 | Урсгал засвар | 6,300,500.00 | 15,605,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 11,366,448.27 | 16,583,605.26 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 9,028,904.96 | 8,353,156.62 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 2,207,968.50 | 8,176,406.47 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 22,133,983.86 | 32,706,685.77 |
| 164 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 139,762,609.58 | 139,342,833.80 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 8,470,961.49 | 5,994,376.80 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 131,221,648.09 | 133,288,457.00 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | 70,000.00 | 60,000.00 |
| 181 | Нормативт зардал | 41,492,300.00 | 50,776,800.00 |
| 183 | Хоол, хүнс | 41,492,300.00 | 50,776,800.00 |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,932,500.00 | 4,000,000.00 |
| 189 | Урсгал засвар | 6,932,500.00 | 4,000,000.00 |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 10,172,375.00 | 16,477,409.61 |
| 195 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 2,797,700.00 | 3,783,900.00 |
| 200 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,374,675.00 | 12,693,509.61 |
| 208 | Бараа үйлчилгээний бусад зардал | 46,784,890.00 | 60,878,946.10 |
| 209 | Бараа үйлчилгээний бусад зардал | 33,917,290.00 | 46,951,146.10 |
| 210 | Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх | 12,867,600.00 | 13,927,800.00 |
| 221 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 62,212,680.42 | 109,893,216.20 |
| 225 | Бусад урсгал шилжүүлэг | 61,472,990.00 | 78,727,550.00 |
| 229 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал | 50,147,690.00 | 53,145,250.00 |
| 233 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 11,325,300.00 | 25,582,300.00 |
| 239 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 739,690.42 | 31,165,666.20 |
| 242 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 739,690.42 | 31,165,666.20 |
| 250 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 157,496,817.31 | 51,558,747.22 |
| 251 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 261 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 37,230,000.00 | 63,074,444.00 |
| 262 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 37,230,000.00 | 63,074,444.00 |
| 263 | Дотоод эх үүсвэрээр | 37,230,000.00 | 63,074,444.00 |
| 267 | Бусад хөрөнгө | 37,230,000.00 | 63,074,444.00 |
| 278 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (37,230,000.00) | (63,074,444.00) |
| 279 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 303 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 120,266,817.31 | (11,515,696.78) |

| | | | |
|---|---|---|---|
| 304 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 43,888,999.20 | 164,155,816.51 |
| 305 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 164,155,816.51 | 152,640,119.73 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 0 | ДАНС | 511 | 51300 | 51210+51220 | |
| 2 | 2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | 318287810.0 | 30439019.0 | 430953613.6 | 779680442.64 |
| 4 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 318287810.0 | 30439019.0 | 430953613.6 | 779680442.64 |
| 8 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | | | -13592704.13 | -13592704.13 |
| 9 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 363659810.0 | 648848328.76 | 579288020.19 | 1591796158.9 |
| 10 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 363659810.0 | 648848328.76 | 579288020.19 | 1591796158.9 |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 363659810.0 | 648848328.76 | 579288020.19 | 1591796158.9 |
| 17 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 0 | 0 | 9584353.51 | 9584353.51 |
| 18 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 363659810.0 | 648848328.76 | 588872373.70 | 1601380512.4 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| SORT_ID | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 164,155,816.51 | (164,155,816.51) | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,484,614,300.00 | 2,238,395,686.58 | 246,218,613.42 | 90.09 |
| 3 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 2,484,614,300.00 | 2,238,395,686.58 | 246,218,613.42 | 90.09 |
| 4 | Бараа, үйлчилгээний зардал | 2,401,145,600.00 | 2,159,668,136.58 | 241,477,463.42 | 89.94 |
| 5 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,775,806,500.00 | 1,681,880,110.15 | 93,926,389.85 | 94.71 |
| 6 | Үндсэн цалин | 1,152,276,500.00 | 1,025,957,748.20 | 126,318,751.80 | 89.04 |
| 7 | Нэмэгдэл | 535,566,100.00 | 552,147,476.42 | (16,581,376.42) | 103.10 |
| 9 | Урамшуулал | 87,963,900.00 | 103,774,885.53 | (15,810,985.53) | 117.97 |
| 11 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 221,975,800.00 | 206,312,036.92 | 15,663,763.08 | 92.94 |
| 12 | Тэтгэврийн даатгал | 150,943,600.00 | 140,492,182.80 | 10,451,417.20 | 93.08 |
| 13 | Тэтгэмжийн даатгал | 17,758,000.00 | 16,583,605.26 | 1,174,394.74 | 93.39 |
| 14 | ҮОМШӨ ний даатгал | 8,879,000.00 | 8,353,156.62 | 525,843.38 | 94.08 |
| 15 | Ажилгүйдлийн даатгал | 8,879,000.00 | 8,176,406.47 | 702,593.53 | 92.09 |
| 16 | Эрүүл мэндийн даатгал | 35,516,200.00 | 32,706,685.77 | 2,809,514.23 | 92.09 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 17 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 170,508,500.00 | 139,342,833.80 | 31,165,666.20 | 81.72 |
| 18 | Гэрэл цахилгаан | 11,077,500.00 | 5,994,376.80 | 5,083,123.20 | 54.11 |
| 19 | Түлш, халаалт | 158,428,500.00 | 133,288,457.00 | 25,140,043.00 | 84.13 |
| 20 | Цэвэр, бохир ус | 1,002,500.00 | 60,000.00 | 942,500.00 | 5.99 |
| 30 | Нормативт зардал | 70,471,100.00 | 50,776,800.00 | 19,694,300.00 | 72.05 |
| 32 | Хоол, хүнс | 70,471,100.00 | 50,776,800.00 | 19,694,300.00 | 72.05 |
| 34 | Эд хогшил худалдан авах | 4,000,000.00 | 4,000,000.00 | - | 100.00 |
| 38 | Урсгал засвар | 4,000,000.00 | 4,000,000.00 | - | 100.00 |
| 43 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 38,259,400.00 | 16,477,409.61 | 21,781,990.39 | 43.07 |
| 44 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,877,600.00 | 3,783,900.00 | 93,700.00 | 97.58 |
| 49 | Мэдээллийн технологийн зардал | 34,381,800.00 | 12,693,509.61 | 21,688,290.39 | 36.92 |
| 53 | Бараа үйлчилгээний бусад зардал | 120,124,300.00 | 60,878,946.10 | 59,245,353.90 | 50.68 |
| 54 | Бараа үйлчилгээний бусад зардал | 104,084,000.00 | 46,951,146.10 | 57,132,853.90 | 45.11 |
| 55 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 16,040,300.00 | 13,927,800.00 | 2,112,500.00 | 86.83 |
| 66 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 83,468,700.00 | 78,727,550.00 | 4,741,150.00 | 94.32 |
| 70 | Бусад урсгал шилжүүлэг | 83,468,700.00 | 78,727,550.00 | 4,741,150.00 | 94.32 |
| 74 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг | 57,886,400.00 | 53,145,250.00 | 4,741,150.00 | 91.81 |
| 78 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 25,582,300.00 | 25,582,300.00 | - | 100.00 |
| 83 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 63,074,444.00 | (63,074,444.00) | - |
| 84 | Дотоод эх үүсвэрээр | - | 63,074,444.00 | (63,074,444.00) | - |
| 88 | Бусад хөрөнгө | - | 63,074,444.00 | (63,074,444.00) | - |
| 97 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,488,491,900.00 | 2,321,120,100.00 | 167,371,800.00 | 93.27 |
| 98 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,310,105,800.00 | 2,142,734,000.00 | 167,371,800.00 | 92.75 |
| 99 | Улсын төсвөөс санхүүжих | 2,310,105,800.00 | 2,142,734,000.00 | 167,371,800.00 | 92.75 |
| 103 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 174,508,500.00 | 174,508,500.00 | - | 100.00 |
| 104 | Орон нутгийн төсвөөс | 174,508,500.00 | 174,508,500.00 | - | 100.00 |
| 110 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 3,877,600.00 | 3,877,600.00 | - | 100.00 |
| 112 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,877,600.00 | 3,877,600.00 | - | 100.00 |
| 127 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 164,155,816.51 | (164,155,816.51) | - |
| 128 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 152,640,119.73 | (152,640,119.73) | - |

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| SORT_ID | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 4 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | - | - | - |
| 102 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | - | - | - |
| 198 | ХӨТӨЛБӨР 71802 | - | - | - | - |
| 199 | АРГА ХЭМЖЭЭ 80109 | - | - | - | - |
| 200 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 174,508,500.00 | 143,342,833.80 | 31,165,666.20 | 82.14 |
| 201 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 174,508,500.00 | 143,342,833.80 | 31,165,666.20 | 82.14 |
| 202 | Бараа, үйлчилгээний зардал | 174,508,500.00 | 143,342,833.80 | 31,165,666.20 | 82.14 |
| 215 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 170,508,500.00 | 139,342,833.80 | 31,165,666.20 | 81.72 |
| 216 | Гэрэл цахилгаан | 11,077,500.00 | 5,994,376.80 | 5,083,123.20 | 54.11 |
| 217 | Түлш, халаалт | 158,428,500.00 | 133,288,457.00 | 25,140,043.00 | 84.13 |
| 218 | Цэвэр, бохир ус | 1,002,500.00 | 60,000.00 | 942,500.00 | 5.99 |
| 232 | Эд хогшил худалдан авах | 4,000,000.00 | 4,000,000.00 | - | 100.00 |
| 236 | Урсгал засвар | 4,000,000.00 | 4,000,000.00 | - | 100.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэл:***

Аймгийн Засаг даргын 2021 оны А/243 тоот захирамжаар "Чадварлаг багш" хөтөлбөр нь 3 зорилтын хүрээнд 14 арга хэмжээ, 2021 оны А/241 тоот захирамжаар "Хүүхдэд ээлтэй дотуур байр" хөтөлбөрийг 4 зорилтын хүрээнд 5 арга хэмжээ,"Монгол бичиг үндэсний "хөтөлбөр 4 зорилтын дагуу 8 арга хэмжээг 2022-2024 онд хэрэгжүүлэхээр баталсан байна. ХИСангаас орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар энтрепренершип боловсрол оолгох төсөл 2020- 2024 eduten, pearson англи хэлний хөтөлбөр хэрэгжиж байна

***Ерөнхий боловсролын сургуулийн зорилго:***

Хүүхэд бүрийн сурч хөгжих, эрүүл зөв амьдрах дадал, үйлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгаж, суралцах тэгш боломжийг бүрдүүлэн, хичээл сургалтын үйл ажиллагаанд бүх талын хамтын оролцоог дэмжих, багш ажилтны ёс зүй, өөрийн удирдлагатай суралцахуй, багшлахуйг эрхэмлэн хөгжүүлэх замаар сургалт, үйл ажиллагааны чанарт ахиц гаргахаар зорилго тавин ажиллаж байна

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Боловсролын тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль
10. Бага дунд боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд ЕБС-ын захирал, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянтэс сумын ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянтэс сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 121,192.9 мянган төгрөгөөр буюу 5 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1.* *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | | 134.9 | 134.9 |
| Бараа материал | 145,957.8 | 116,555.4 | -29,402.4 |
| Үндсэн хөрөнгө | 1,281,918.0 | 1,402,989.0 | 121,192.9 |
| **Нийт хөрөнгө** | **1,591,796.1** | **1,672,319.5** | **80,523.4** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,591,796.1 | 1,601,380.3 | 9,584.2 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,591,796.1** | **1,672,319.5** | **80,523.4** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Авлагын эхний үлдэгдэлгүй, тайлант онд 134,9 мянган төгрөгийн авлага нэмэгдсэн байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 145,957.8 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 160.525.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Хандиваар 11,600.0 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 152,808.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 37,099.0 мянган төгрөгийн бараа материал акталж, эцсийн үлдэгдэл 116,555.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 29,402.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 100,473.6 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 84,322.4 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 41,596.5 мянган төгрөгийн хөрөнгө акталж жилийн эцэст 1,402,989.0 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант оны элэгдлийн зардалд 96,567.9 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 249,268.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,154,752.0 мянган төгрөг, нийт зарлагыг 2,154,752.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг тодотголоор нэмж баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн зардлын гүйцэтгэл 1 хөтөлбөр, 14 арга хэмжээнд нийт 2,140,615.3 мянган төгрөг буюу 99.3 хувьтай зарцуулж ажилласан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| Хөтөлбөрар га хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | | | | |
| 71802 | Ерөнхий боловсрол<br>Сургуулийн өмнөх боловсрол | | | | |
| 80226 | Ба[illegible] | 3,892.40 | 2,477.00 | 1,415.40 | 63.6 |
| 80217 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 2,886.20 | | 2,886.20 | 0 |
| 80233 | Хүүхэд хамгаалал | 37,763.70 | 37,763.70 | | 100 |
| 80312 | Сургалт семинар | 2,738.10 | 2,738.10 | | 100 |
| 81605 | Эрүүл мэндийг дэмжих | 5,504.00 | 3,203.00 | 2,301.0 | 58.1 |
| 81801 | Үдийн цай хөтөлбөр | 57,886.40 | 53,145.25 | 4,741.15 | 91.8 |
| 81806 | Дотуур байрны үйлчилгээ | 235,174.90 | 235,174.90 | | 100 |
| 81816 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 11,811.90 | 11,811.90 | | 100 |
| 81823 | Боловсролын байгууллагын багш ажилтаны мэргэжил дээшлүүлэх | 18,708.10 | 18,708.10 | | 100 |
| 81834 | Боловсролын стандарт | 1,635,143.00 | 1,635,143.00 | | 100 |
| 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 134,220.30 | 134,220.30 | | 100 |
| 81848 | Сурах бичгийн түрээс | 3,877.60 | 3,783.90 | 93.7 | 97.5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 81875 | Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх | 5,027.60 | 2,446.11 | 2,581.49 | 48.6 |
| 83603 | Нэмэлт-дээд шатны төсвөөс хувиарласан | 118.00 | 0 | 118.00 | 0 |
| **НИЙТ** | | **2,154,752.20** | **2140615.3** | **14,136.9** | **99.3** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 71802 | Ерөнхий боловсрол | | | | |
| 80109 | ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал | 174,508.5 | 143,343.4 | 31,165.06 | 82.1 |
| НИЙТ | | **174,508.5** | **143,343.4** | **31,165.06** | **82.1** |

Орон нутгын санхүүжилтээр 174,508.5 мянган төгрөгийн тогтмол зардал төвлөрүүлж, батлагдсан төсвийн дагуу 143,343.4 мянган төгрөгийг зарцуулж, 31,165.06 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/мянган төгрөг/*

| № | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| 1 | Шууд гэрээ байгуулах | Үдийн цай | 57,886.4 | 53,145.2 |
| 2 | Шууд гэрээ байгуулах | Урсгал засвар | 4,000.0 | 4,000.0 |
| 3 | Шууд гэрээ байгуулах | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 38,259.4 | 16,477.4 |
| 4 | Шууд гэрээ байгуулах | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,877.6 | 3,783.9 |
| 5 | Шууд гэрээ байгуулах | Мэдээллийн технологийн зардал | 34,381.8 | 12,693.5 |
| 6 | Шууд гэрээ байгуулах | Бараа үйлчилгээний бусад зардал | 120,124.3 | 60,878.9 |
| 7 | Шууд гэрээ байгуулах | Бараа үйлчилгээний бусад зардал | 104,084.0 | 46,951.1 |
| 8 | Шууд гэрээ байгуулах | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 16,040.3 | 13,927.8 |
| 9 | Шууд гэрээ байгуулах | Хоол, хүнс | 70,471.1 | 50,776.8 |
| **ДҮН** | | | **449,124.9** | **262,634.6** |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянтэс сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Хаан соёмбо аудит" ХХК-ийн гэрээт аудитор Ж.Буянтогтох гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн анхан шатанд хянаж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Баянтэс сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,624,961.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 16,219,6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 12,975.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,407,458.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 24,074.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 19,259.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар
**Завсрын аудит хийгдээгүй байна.**

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1209,7 мянган төгрөгийн зөрчилд 1акт өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажилласан байна

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 1209.7 | 1 | 1209.7 | 100 |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **1209.7** | **1** | **1209.7** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар хүүхдийн хоол, үдийн цайны зарцуулалтанд хяналт тавьж ажиллах.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,530.6 мянган төгрөгийн зөрчил илэрч 3 зөвлөмж өгөв.

***Залруулсан алдаа:*** *Залруулсан алдаа байхгүй*

**5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй**

**5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй**

**5.3 Зөвлөмж**

**1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой**

- ***Илэрүүлэлт -1:*** Шатахуун авсан замын хуудас нь хэн хаашаа явсан нь тодорхойгүй явсан хүний гарын үсэггүй, тооцоог бодоогүй, дуудсан бичиггүй, тооцооны хуудсаар шатахууны тооцоог бодохдоо ажлын зорилго, зориулалтыг бичээгүй, авто машиныг

эзэмшиж явсан албан тушаалтан ажлын тайлан бичиж хавсаргаагүй 11,639.1 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

***Өгсөн зөвлөмж:***

Жолоочийн замын хуудсыг тодорхой бичиж , авто машиныг эзэмшиж явсан албан тушаалтаны гарын үсгээр баталгаажуулан, ажлын тайлан иотгэх хуудас хавсаргаж байх

- ***Илэрүүлэлт -2:***

  Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 153 төрлийн 287,576,954 мянган төгрөгийн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэгдэл өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ируүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

  ***Өгсөн зөвлөмж:*** Дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;

- ***Илэрүүлэлт-3:***

  Сургуулийн шинээр барих 100 хүүхдийн дотуур байрны геологийн судалгааны хөлсөнд урсгал засврын зардлаас 891.5 мянган төгрөгийг олгосон

  ***Зөвлөмж:***

  Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2.батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаж, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", -ыг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Урсгал засвараас шинээр барих 100 хүүхдийн дотуур байрны геологийн судалгааны хөлсийг олгосон | 1 | 891,5 | | | | | 1 | 891.5 | | | | |
| Шатахуун авсан замын хуудсыг хэзээ хэн хаашаа явсан нь тодорхойгүй явсан хүний гарын үсэггүй, тооцоог бодоогүй, дуудсан бичиггүй, Жолоочийн тооцооны хуудсаар шатахууны тооцоог бодохдоо ажлын зорилго, зориулалтыг бичээгүй, авто машиныг эзэмшиж явсан албан тушаалтан ажлын тайлан бичиж хавсаргаагүй | 1 | 11,639,1 | | | | | 1 | 11,639.1 | | | | |
| Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 153 нэрийн 287576954 төгрөгийн хөрөнгө 0 үлдэгдэлтэй байгаа | 1 | | | | | | 1 | | | | | |
| **Дүн** | **3** | **12530,6** | | | | | **3** | **12,530.6** | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД

АУДИТЫН МЕНЕЖЕР: Х.БОЛДБААТАР

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2025-02-24

**БОЛОВСРУУЛСАН:**

"ХААН СОЁМБО АУДИТ" ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР Ж.БУЯНТОГТОХ

Огноо: 2025-02-24